



ӨМНӨХ ҮГ

Манай хамт олон өнгөрч буй онд хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх ашгийг дээдлэн, гадаадын болон өөрийн орны иргэд, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд түргэн шуурхай, хүнд сурталгүй, олон улсын жишигт нийцүүлэн хүртээмжтэй хүргэхийг хичээж ажиллалаа.

2019 онд бид төрийн үйлчилгээг цахимжуулж иргэдэд ойртуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, албан хаагчдынхаа нийгмийн баталгааг хангах, гадаад, дотоодын давтан сургалтад хамруулах, мэргэшүүлэх зэрэгт анхаарч ажилласнаас гадна бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг хэрэгжүүлж эхлээд байна.

Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд өгөх байгуулмагын саналыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлж, дагаж гарах Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулаа.

Түүнчлэн иргэд, үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ, шаардлагад тулгуурлан, иргэн төвтэй төрийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор визийн зөвшөөрөл олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн зэрэг ажлын ололт, амжилтаар дүүрэн 2020 оноо угтаж байна.

Энэхүү эмхэтгэлээр хамт олны 2019 онд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хураангуй тайланг танилцуулж байна.

Ирж буй шинэ ондоо ажлын амжилт, амьдралын сайн сайхан бүхнээр дүүрэн байхыг билэгдэн ерөөе.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ДАРГА, МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ

ДАШДОРЖИЙН МӨРӨН



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС 2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 18

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль, “2019 оныг иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил болгон зарлах тухай” Засгийн газрын 23 дугаар тогтоол болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1.1 ВИЗ, ЗӨВШӨӨРЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх гадаадын иргэдэд холбогдох төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 25819 визийн зөвшөөрөл, 30318 виз олгож, 357 иргэнд Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгосон байна.

15352 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 23146 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 15945 иргэний бүртгэлд хасалт хийсэн бөгөөд статус нь өөрчлөгдсөн 551 гадаадын иргэний визийн ангиллыг сольж, Монгол Улсад түр ирэгчээр ирсэн гадаадын 25052 иргэнийг бүртгэлээ.

“Монгол Улсад оршин суух үнэмлэх” 27449 ширхгийг шинээр олгож, 12415 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 616 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ. Цагаач, гэр бүлийн шалтгаанаар оршин суугч гадаадын 176 иргэнд хувийн хэрэг шинээр нээж, 2104 иргэний хувийн хэрэгт баяжилт хийн нийт 2109 иргэний мэдээллийг цахим архивт оруулсан байна. Гадаадын 38 иргэнд регистрийн дугаар олгож, харьяалалгүй зургаан хүнд зорчих үнэмлэх олгосон.


Цахим визийн зөвшөөрлийн үйлчилгээг 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж тайлант хугацаанд олон улсын хилийн боомт дээрээс “J” ангиллын 1861, “S” ангиллын 414, “A” ангиллын 16, “B” ангиллын 711 визийн зөвшөөрөл, “B” ангиллын олон удаагийн гарах-орох 1346 визийн зөвшөөрөл, нийт давхардсан тоогоор 2499 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч хянан, 1651 аж ахуйн нэгж, байгууллагын 4348 гадаадын иргэний визийн зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянан цахимаар шийдвэрлэсэн байна.



Мөн 198 аж ахуйн нэгж, байгууллагын 327 иргэний хүсэлтийг татгалзсан байна.

Үйлчилгээний танхимд нийт 19032 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч үйлчилсэн нь өдөрт дунджаар 80 иргэн, аж ахуйн нэгж болж байгаа юм.

Нийт 35,720 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 19393, 7585-1882 дугаарын утсаар 1050, биечлэн 6375, автомат хариулагчаар 8902 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх Хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвд тус байгууллагын т ажиллаж тайлангийн хугацаанд 1404 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, гадаадын 444 иргэнд визийн зөвшөөрөл, 582 иргэнд оршин суух зөвшөөрөл олгож, 1318 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, 200 иргэний ангиллыг сольж, 102 иргэнд бүртгэл, 29 иргэнд хаягийн өөрчлөлт, 162 иргэнд хасалт хийсэн байна. Мөн хөрөнгө оруулагчаар оршин суух зөвшөөрөлтэй 1304 иргэнд зохих ангиллын виз олголоо.



2019 оны дээрх тоон үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 6.6 хувиар, виз олголт 8.6 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 6.6 хувиар, түр ирэгчийн бүртгэл 2.6 хувиар, түр ирэгчийн хасалт 1.8 хувиар өссөн, харин хувийн урилга олголт 7.0 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 0.1 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 8.8 хувиар, визийн сунгалт 20.6 хувиар тус тус буурсан байна.

Иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр



Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан хоёр улсын гурван иргэн, харьяалалгүй таван хүний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан хоёр улсын найман иргэн, харьяалалгүй долоон хүний хүсэлтийг шийдвэрлүүлэхээр Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлээ. Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн есөн удаагийн зарлигаар дөрвөн улсын 21 иргэн, харьяалалгүй таван хүн Монгол Улсын харьяат болсон байна.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан хоёр улсын хоёр иргэн, харьяалалгүй есөн хүний нийт 11 хүсэлтийг шинээр хүлээн авсан ба хуульд заасан шалгуурыг хангаагүй есөн хүсэлтийг буцаасан байна.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын 11 улсын харьяат болох хүсэлт гаргасан 321 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, 328 иргэний хүсэлтэд холбогдох газраас санал авах ажиллагааг хийсэн.


Монгол Улсын харьяатаас гарч гадаадын 11 улсын харьяат болох хүсэлт гаргасан 323 иргэний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн ба 267 иргэний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулсны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьсан байна. Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 14 удаагийн зарлигаар 265 иргэн Монгол Улсын харьяатаас гарчээ.

Монгол Улсын иргэний харьяалмаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй 25 хүний хүсэлтийг шинээр хүлээн авсан бөгөөд нэг улсын таван иргэн, харьяалалгүй 20 хүний баримт бичгийг хянан холбогдох газраас санал авах ажиллагааг хийсэн байна.

Иргэний харьяалмаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй 13 хүний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, харьяалалгүй 18 хүний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулсны дагуу Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоёр удаагийн зарлигаар харьяалалгүй 121 хүн Монгол Улсын иргэний харьяалмаа сэргээн тогтоолгожээ.

Түүнчлэн хоёрдмол харьяалал үүсгэсэн 641 иргэнийг бүртгэж мэдээллийн санд оруулсан ба нийт 3555 иргэн бүртгэлтэй байна.



Тайланг хугацаанд Мэргэжлийн зөвлөлийн хурлаар 49 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын асуудлыг хэлэлцүүлэн дөрвөн байгууллагад шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгон, 72 байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгаж, есөн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгон, гурван байгууллагын хүсэлтийг түдгэлзүүлэн, нэг байгууллагын хүсэлтэд татгалзсан байна. Түүнчлэн 63 төрийн бус байгууллагын хүсэлтийг шинээр хүлээн авсан. 2019 оны жилийн эцсийн байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 89 төрийн бус байгууллага байна.



2005-2012 онд “Холт интернэшнл” хүүхдийн төлөө олон улсын байгууллагаар зуучлуулан Америкийн Нэгдсэн Улсын 3 гэр бүлд үрчлэгдсэн 7 хүүхдийг эх орныхоо өв соёл, зан заншилтай танилцах арга хэмжээг зохион байгууллаа.



Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан хоёр улсын гурван гэр бүлийн хүсэлтийг шинээр хүлээн авч холбогдох ажиллагааг эхлүүлснээс Монгол Улсын харьяат хоёр хүүхдийг холбогдох журмын дагуу үрчлүүлж, үрчлэлтийн дараа хяналт тавих гурван талт гэрээг байгуулсан.

Байгууллагын дарга болон хүүхэд үрчлэлт хариуцсан мэргэжилтэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Итали Улсын иргэн, гэр бүлд 2003-2019 оны хооронд үрчлэгдсэн 25 хүүхдүүдийн нөхцөл байдалтай биечлэн танилцсан.

Гадаадын гэр бүлд үрчлэгдсэн 41 хүүхдийн үрчлэлтийн дараа хяналт тавих тайланг хүлээн авч мэдээллийн санд бүртгэсэн ба 2018 онд тайлан ирүүлээгүй 36 хүүхдийн судалгааг гаргаж Гадаад харилцааны яамны Консулын газарт хүргүүлсэн. Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан гадаад улсын нэг гэр бүл нь “Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц”-ийн дагуу холбогдох судалгааг эрх бүхий байгууллагаар хийлгүүлээгүй тул хүсэлтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд буцаан хүргүүлэв.



1.2 ХЯНАЛТ ШАЛГАЛТ, АЛБАДАН ГАРГАХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:



Тайлангийн хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 26 улсын 1509 иргэн, харьяалалгүй нэг хүнийг байгууллагын даргын 170 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа. Мөн байгууллагын даргын 13 удаагийн тушаалаар Монгол Улсаас албадан гаргасан таван улсын 15 иргэний Монгол Улсаас албадан гаргасан тушаалыг хугацаанаас өмнө цуцалж, харьяалалгүй нэг хүний Монгол Улсаас албадан гаргасан хугацаанд өөрчлөлт оруулан, гурван удаагийн тушаалаар дөрвөн улсын зургаан иргэний Монгол Улсаас албадан гаргах тухай тушаалын хугацаанд өөрчлөлт оруулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын 35 удаагийн тушаалаар найман улсын 37 иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, 23 удаагийн тушаалаар найман улсын 27 иргэний хилээр нэвтрэх эрхийг сэргээн ажиллалаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу 1799 гадаадын иргэнийг орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан ба зохих бичиг баримтын бүрдэл хангаагүй 122 гадаадын иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаажээ.



Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн 24 удаагийн захирамжаар гадаадын таван улсын 24 иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн дэргэдэх гадаадын иргэнийг саатуулах байранд саатуулсан. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндэслэлээр 13 улсын 83 иргэнд гарах сануулга өгсөн ба Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг үндэслэн долоон аж ахуйн нэгжид хяналтын улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, консулын газар, өргөмжит консулаас визийн хүчинтэй хугацаа, нэр огноо буруу, визийн зориулалт бичигдээгүй зэрэг гадаадын 708 иргэнд олгогдсон визийг тухай бүр хуулбарлан авч, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолын дагуу дагуу визийг дахин олгон хил нэвтрүүлээ.

Тайлангийн хугацаанд 72 удаагийн төлөвлөгөөт, 231 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 1599 аж ахуйн нэгж, байгууллага, 18,825 гадаадын иргэнийг хамруулсан ба 2105 гадаадын иргэн, 1487 аж ахуйн нэгж, байгууллага /3625 гадаадын иргэн/, 276 уригч иргэн /27 гадаадын иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 2,578,350,000 /хоёр тэрбум таван зуун далан найман сая гурван зуун тавин мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээ.



2019 оны дээрх тоон үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 11.8 хувиар, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 33.4 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 2.8 дахин өссөн, харин зөрчил гаргасан уригч иргэн 35.0 хувиар, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 14.0 хувиар тус тус буурсан байна.

Тус байгууллагаас 2019 онд нийт 7 тэрбум 498,5 сая төгрөгийг тэмдэгтийн хураамж, хүү торгууль, визийн хуудасны орлогыг улсын төсөвт төвлөрүүлээ.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1 ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ДОТООД АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/227 дугаар тушаалаар тус байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц орон тоог шинэчлэн баталсны дагуу 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс зохион байгуулалтын шинэ бүтцээр ажиллаж эхэлсэн. Байгууллагын даргын 2018 оны Б/347 дугаар тушаалаар Гадаадын иргэн, харьяатын газрын орон нутаг дахь нэгжийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн баталж, Б/364 дүгээр тушаалаар нийт албан хаагчдыг албан тушаалаас нь чөлөөлж, Б/365 тушаалаар албан тушаалд томилов.

Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээ, байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2018 он, 2019 оны эхний хагас жил, Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолын 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн, Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлснээр хэрэгжилтийг хурлын тэмдэглэлийн хамт, байгууллагын 2018 он, 2019 оны сар, эхний хагас жилийн тайлан, байгууллагын үйл ажиллагааны сар бүрийн инфографик тоон мэдээллийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд холбогдох хугацаанд хүргүүлэн ажилласан.

"Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" Засгийн газрын 2017 оны нэгдүгээр албан даалгаврын хүрээнд байгууллагын даргын 2019 оны 01 дүгээр албан даалгавар болон Засгийн газрын 2019 оны "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил" болгох тухай 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг байгууллагын даргын 2019 оны А/136 дугаар тушаалаар батлан, нийт албан хаагчдад хүргүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллалаа.

Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвд тус байгууллагаас үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангаж, 02 дугаар сараас гадаадын хөрөнгө оруулагчдад үйлчилж эхэллээ.



Төрийн албаны тухай хуультай холбогдуулан Улсын Их Хуралын гурав, Засгийн газрын 11, Төрийн албаны зөвлөлийн зургаан тогтоол, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан нэг тушаал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын нэг тушаалыг эмхэтгэн 2019 оны "Мэдээлэл 1", "Мэдээлэл 2", "Мэдээлэл 3" сэтгүүлийг хэвлүүлж, албан хаагчдад хүргүүлэн, хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэн ажиллав.



Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын дагуу байгууллагын даргын 2019 оны А/112 дугаар тушаалаар “Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлах” тухай ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэг нийт 6 удаа хуралдаж, төрийн захиргааны 52 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан бусад баримт бичгийн хамт салбар зөвлөлийн 2019 оны 05 дугаар сард 17 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн хянуулсан.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 57 дугаар тогтоол гарснаар төрийн захиргааны 52 албан тушаалын тодорхойлолтыг байгууллагын даргын 2019 оны А/324 дүгээр тушаалаар баталсан. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3.2-т заасныг үндэслэн төрийн үйлчилгээний 32 албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг байгууллагын даргын 2019 оны А/345 дугаар тушаалаар баталсан.

Тус байгууллага нь хуваарийн дагуу төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үлсын үзлэгт 11 дүгээр сард хамрагдаж албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа 95 хувь, байгууллагын архивын ажил 99 хувь, төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлж буй байдал 96 хувь, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт 97 хувь, нийлбэр дүнгээр 96.7 хувьтай амжилттай дүгнэгдлээ.



Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үлсын үзлэгт бэлтгэх зорилгоор байгууллагын даргын хоёр төлөвлөгөө, зургаан удаагийн удирдамжийн дагуу байгууллагын төв болон Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Агаарын замын боомт хариуцсан газар, Сэлэнгэ аймаг дахь Хойд бүс дэх газар, Дорнод аймаг дахь Зүүн бүс дэх газар, Дорноговь аймаг дахь газрын албан хаагчдын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, холбогдох дүрэм, зааврын хэрэгжилтэд үзлэг шалгалт хийн, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах үүрэг, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан



Байгууллагын даргын 832 тушаал /үндсэн үйл ажиллагаатай холбоотой 506, хүний нөөцтэй холбоотой 326/, есөн албан даалгавар баталсныг хэрэгжилтийг ханган, цахим сан үүсгэж ажиллалаа.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 655 өргөдөл, 17 гомдол ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 646 өргөдөл, 17 гомдол шийдвэрлэгдэж, есөн өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.

Тайлант хугацаанд байгууллагын “Мэргэжлийн зөвлөл” 11 удаа, “Даргын дэргэдэх зөвлөл” 12 удаа хуралдаж, тодорхой асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрийн биелэлтийг хангуулан ажиллалаа.

Албан хаагчдын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 24 удаагийн дотоод хяналт шалгалтыг зохион байгуулсан ба ажлын цаг ашиглалтад 12 удаа, албан хаагчдын дүрэмт хувцас өмсөх, хэрэглэх журмын хэрэгжилтэд зургаан удаа хяналт тавьсан.



Хүний нөөцийн чиглэлээр:

Тайлангийн хугацаанд 11 албан хаагчид гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн эрх, гурван албан хаагчид гадаадын иргэнд олгох виз, хувийн урилгад батламжлан гарын үсэг зурах эрх олгож, "Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам"-ын дагуу таван төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлэн төрийн жинхэнэ албан хаагчид хамруулав.



2018 оны ажлын үр дүнг дүгнэсэн үзүүлэлтээр А, В дүгнүүлсэн 104 албан хаагчийн цалингийн 70-80 хувийн буюу 54,4 сая, хилийн боомт, орон нутаг дахь албанд таваас доошгүй жил ажилласан 15 албан хаагчид Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41.8-д заасны дагуу 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал 301,7 сая төгрөгийг олгосон байна. Мөн байгууллагын бүтээн байгуулалтын ажилд идэвх зүтгэл гарган ажилласан 20 албан хаагч, шинэ санаа, санаачилга гарган ажилласан найман албан хаагчид тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал болох 14,3 сая төгрөгийг байгууллагын даргын тушаалаар олгосон.

Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолын дагуу байгууллагын төрийн захиргааны 151 албан хаагчийн судалгааг гаргаж Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж байгууллагын даргын тушаалаар шинээр 14 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдэл олгож, есөн албан хаагчийн зэрэг дэвийг шинэчлэн тогтоосон байна.

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох болзол хангасан нэг албан хаагчид шинээр, зургаан албан хаагчид шинэчлэн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын дагуу төрийн захиргааны 114 албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийг тус тус шинэчлэн тогтоосон. Засгийн газрын 2019 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" 275 дугаар тогтоол, "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай" 277 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны 13 албан хаагчийн ангилал зэрэглэлийг шинэчлэн баталлаа.

Эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл гарган ажилласан нэг албан хаагч "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон", нэг албан хаагч "Цэргийн хүндэт медаль"-аар, таван албан хаагч "Хөдөлмөрийн хүндэт медаль"-аар, долоон албан хаагч Хууль зүй, дотоод хэргийн яамны жуух бичгээр, дөрвөн албан хаагч Сангийн яамны хүндэт жуух бичгээр, долоон албан хаагчийг байгууллагын Хүндэт тэмдгээр, 20 албан хаагчийг Хүндэт өргөмжлөөр, 30 албан хаагч, нэг нэгжийг мөнгөн шагналаар шагнаж, дөрвөн албан хаагчийг 2018 оны Хөдөлмөрийн аваргаар шалгаруулан, нэг албан хаагчийг Хүндэт дэвтэрт бичин алдаршуулав.



Албан хаагчдын цалингийн шатлал, зэрэг дэвийн судалгааг гаргаж байгууллагын даргын 2019 оны Б/275 дугаар тушаалаар төрийн захиргааны 70 албан хаагчийн цалингийн шатлал, Б/276 дугаар тушаалаар төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийг 30 албан хаагчид шинээр, 44 албан хаагчид ахиулан олголоо.

"Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 90 дүгээр захирамжийн дагуу дөрвөн албан хаагчийн төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийн нэмэгдэл хөлсийг шинэчлэн баталсан.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу 278 албан хаагчийн хувийн хэргийг баяжуулж, Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системд байгууллагын төвийн 114 албан хаагчийн сар бүрийн тогтмол нэмэгдэл болон албан тушаалын өөрчлөлтүүдийн мэдээллийг 2019 оны 10 дугаар сарын байдлаар шинэчлэн оруулсан.





Сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22 дугаар албан бичгээр хүргүүлснээр Төрийн албаны зөвлөлөөс зарыг 10 дугаар сарын 11-ний өдөр “www.csc.gov.mn” цахим хаягаар олоннийтэд зарласан. Тус зарыг байгууллагын “immigration.gov.mn” цахим хуудас болон Гадаадын иргэн, харьяатын газрын цахим сүлжээнд тус тус байршуулж олон нийтэд мэдээлснээс гадна орон нутагт ажимаж буй төрийн албан хаагчдаас бүртгэлд хамруулж хамтран ажиллах тухай Төрийн албаны зөвлөлийн Дундговь болон Дорнод аймаг дахь салбар зөвлөлд 10 дугаар сарын 14-ний өдрийн 24, 25 дугаар албан бичгийг хүргүүлсэн.



Сургалтын чиглэлээр:

Тайлант хугацаанд дотоодын богино, дунд хугацааны 186 сургалтад давхардсан тоогоор 3713 албан хаагч, урт хугацааны сургалтад 5 албан хаагч, гадаадын богино, дунд хугацааны 9 сургалтад 24 албан хаагч, урт хугацааны сургалтад 5 албан хаагч хамрагдаж төгссөн, 7 албан хаагч хамрагдаж байна. Үүнээс байгууллагаас эрх олгох сургалт 1, шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх 2, албан хаагчдыг мэргэшүүлэх 2, албан хаагчдыг чадавхжуулах 7, мэдээллийн цагт богино хэмжээний сургалт 21, нийт 34 сургалтыг зохион байгуулж ажилласан ба эдгээр сургалтад давхардсан тоогоор 2652 албан хаагчийг хамруулсан.



“Шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх” сургалтад хамрагдсан 4, “Захиргааны албан хаагчдын сургалт”-д хамрагдсан 36, “Баримт бичгийн нууцлалын үзүүлэлт” сэдэвт сургалтад хамрагдсан 19 албан хаагч, нийт мэргэшүүлэх 3 сургалтад хамрагдсан 59 албан хаагчид сертификат олголоо. “Хяналтын улсын байцаагчийн эрх олгох сургалт”-д 12 албан хаагч хамрагдаж, шалгалтыг зохион байгуулсан.



Гадаадын иргэн, харьяатын газар, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран “Гадаадын иргэн, харьяатын газрын удирдах албан тушаалтан, хяналтын улсын байцаагчдын сургалт, зөвлөгөөн”-ийг 2019 оны 09 дүгээр сарын 11-ээс 15-ны өдрийн хооронд Өмнөд бүс дэх газарт амжилттай зохион байгуулаа. Сургалт, зөвлөгөөнд байгууллагын төв болон орон нутаг дахь газрын 50 гаруй албан хаагч хамрагдлаа.



Байгууллагын чиг үүрэг, онцлогийн талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад 10 удаагийн сургалт зохион байгуулж, 543 иргэн хамрагдсан ба бусад байгууллагаас зохион байгуулсан 29 сургалтад 117 албан хаагч хамрагдсанаас 57 албан хаагч нь мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна.

Тайлант хугацаанд Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Тайвань, Катар, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Тажикстан Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсад араб хэл, хилийн менежмент, гамшиг, онцгой байдлын үед дэх хамтын ажиллагаа, Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын чадавх бэхжүүлэх чиглэлээр богино хугацааны сургалтад 24 албан хаагчийг хамруулсан бол Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Тайвань, Бүгд Найрамдах Турк Улсад урт хугацааны сургалтад долоон албан хаагч хамрагдаж байна.

Түүнчлэн байгууллагын “Сургалтын модуль”-ийг боловсруулан байгууллагын даргын 2019 оны А/430 дугаар тушаалаар батлуулсан.



Олон нийттэй харилцах чиглэлээр:

Байгууллагын цахим хуудаст 126 мэдээлэл нийтэлснээс 87 мэдээ, долоон ярилцлага, 14 видео бичлэг, 36 үйл ажиллагааны тайлан мэдээ, 12 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, таван тендерийн шалгаруулалтын зар мэдээ байна.

Удирдлагын түвшинд барьж буй бодлого, шийдвэрийг олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг эрчимжүүлэх, байгууллагын эрхлэх чиг үүрэг, иргэд олон нийтэд үзүүлэх үйлчилгээ, хууль эрх зүйн зохицуулалт, онцлогийг таниулах зорилгоор тодорхой чиглэлүүдээр ярилцлагуудыг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэв. Тухайлбал: Монголын үндэсний олон нийтийн телевизийн "Иргэний эрх зүйн боловсролд" нэвтрүүлэгт "Гадаадын иргэдийн виз, зөвшөөрөл, хяналт шалгалт" сэдвээр, "Эрх зүйн хөтөч" нэвтрүүлэгт "Виз зөвшөөрлийн цахим үйлчилгээ", "Жуулчин ангиллын виз, жуулчдын анхаарах зүйл" сэдвээр тус бүр 20 минутын нэвтрүүлэг бэлтгэн, мөн "Eagle", "UBS" телевизийн "Зочны цаг", "SBN" телевизийн "Бодит тайлбар" шууд нэвтрүүлэгт холбогдох албан хаагч оролцон, байгууллагын үйл ажиллагааг сурталчлан ажиглалаа. Дээрх нэвтрүүлгүүдийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудсанд байршуулсан.



Тайлант хугацаанд гадаадын иргэдийн бүртгэлийн журам, визийн зөвшөөрлийн цахим үйлчилгээний танилцуулга, цахим үйлчилгээний заавар, "HG" ангиллын визийн зөвшөөрлийг цахимаар олгох тухай мэдээлмээр нийт дөрвөн богино хэмжээний видео бичлэг бэлтгэж цахим сүлжээ болон Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз болон олон нийтэд түгээн ажиглалаа. Мөн цахим үйлчилгээтэй холбоотой бичлэгийг Англи, Хятад, Солонгос, Орос хэл дээр бэлтгэж олон нийтэд хүргэлээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж байгууллагын холбогдох хууль тогтоомжийг сурталчилсан видео санамж мэдээллийг дохионы хэлээр орчуулах ажлыг зохион байгуулаа. Энэ хүрээнд гадаадын иргэдийн бүртгэлийн журамтай холбоотой санамж (90 секунд), цахим үйлчилгээтэй холбоотой санамж (55 секунд), цахимаар визийн зөвшөөрөл мэдүүлэх заавар (3 минут), уригч иргэн, аж нэгж, байгууллагуудад зориулсан анхааруулах санамж (57 секунд)-ийг тус тус бэлтгэж байгууллагын цахим хуудаст байршуулав.



Байгууллагын үйл ажиллагаа, гадаадын иргэнтэй холбоотой тоон мэдээллийг 2019 оны эхний 10 сарын байдлаар сэтгүүлчдэд танилцуулж, цаг үеийн асуудлаар тайлбар мэдээлэл хийсэн хэвлэлийн бага хурлыг Нийслэлийн хэвлэл мэдээллийн төвд зохион байгуулаа. Хэвлэлийн хуралд 18 телевиз, 14 цахим хуудас, долоон сонин, нийт 29 байгууллагын 50 орчим сэтгүүлч, сурвалжлагчид хүрэлцэн ирж, мэдээ, ярилцлага, сурвалжилга бэлтгэн олон нийтэд хүргэв. Хэвлэлийн хурлын үеэр байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тоон мэдээллийг нэгтгэсэн гарын авлага, хяналт шалгалт хийж буй 13 минутын дүрс бичлэг хувилсан DVD-г сэтгүүлчдэд хүргүүлэв.



Гадаад харилцааны яам, Гадаадын иргэн, харьяатын газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Элчин сайдын яамны хамтарсан хэвлэлийн бага хурал 08 дугаар сарын 26-ны өдөр Бүгд Найрамдах Солонгос Улсын Элчин сайдын яаманд болсон бөгөөд хуралд байгууллагын Д.Мөрөн оролцож, сэтгүүлчдэд мэдээлэл өгөв.

"Монголын үндэсний олон нийтийн телевиз", "UBS" телевизийн "Зочны цаг"-т байгууллагын дарга оролцож, цаг үеийн асуудлаар мэдээлэл, "SBN" телевизийн "Бодит тайлбар" нэвтрүүлэгт хяналтын улсын ахлах байцаагч оролцож гадаадын иргэдийн хяналттай холбоотой нийгмийн сүлжээнд тавигдсан мэдээлмүүдэд бодит тайлбар өглөө.



Архив, албан хэрэг хөтөлтийн чиглэлээр:

Архивын тухай хуулийн 23.6, 23.1.7, заалт, байгууллагын архивын ажлын үндсэн зааврын 9.14, 9.17 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2003-2009 оны байнга хадгалах 401 хадгаламжийн нэгжийг Үндэсний төв архивт хүлээлгэн өгсөн.

Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар баталсан “Байгууллагын архивын ажлын үндсэн зааврын 2.4.5, 2.4.6-д заасны дагуу байгууллагын архивт хадгалагдаж буй 2015-2017 оны 759 хадгаламжийн нэгжийн хадгалах хугацаа дуусаж түүх, эрдэм шинжилгээний ач холбогдолгүй болсон тул зохих журмын дагуу устгалд оруулсан болно.

Эрүүл мэнд, спортын чиглэлээр:

Тайлангийн хугацаанд эрүүл мэндийн өдөр тутмын үзлэг оношилгоонд 221 албан хаагч хамрагдсан. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд элэгний В, С вирусыг илрүүлэх урьдчилсан шинжилгээг Хан-Уул дүүргийн 16 дугаар хорооны “Энх-Буюнт Манал” өрхийн эмнэлэгтэй хамтран 04 дүгээр сард байгууллагын төвд зохион байгуулж нийт 17 албан хаагч хамрагдлаа.

Улсынхэмжээндзохиогдсондархлаажуулалтын 10 хоногийн аяны хүрээнд байгууллагын төвийн 107 албан хаагчаас судалгаа авч 59 албан хаагчийг 10 дугаар сард Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвд томуугийн эсрэг сайн дурын вакцинжуулалтад хамруулан шаардлагатай зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллалаа.



Албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын биеийн тамир, спортын арга хэмжээний 2019 оны төлөвлөгөөг батлан, 03 дугаар сард сагсан бөмбөг, 04 дүгээр сард гар бөмбөг, 05 дугаар сард бильярд, 07 дугаар сард дартс, 10 дугаар сард ширээний теннис, 11 дүгээр сард бадминтон буюу агаарын теннисийн тэмцээнийг тус тус зохион байгуулж ажиллалаа.



Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, байгууллагуудын дунд жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг спортын дөрвөн төрөлт тэмцээнд баг, хамт олноороо амжилттай оролцож гар бөмбөгийн төрөлд эрэгтэй баг гуравдугаар байр эзэлж, олс таталтын төрөлд дөрөвдүгээр байр, багийн дүнгээр тавдугаар байранд жагсан өмнөх оны амжилтаа ахиулсан.





2.2 САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭ

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын төсвийн тухай хуулийн дагуу 6,2 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 5,4 тэрбум төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулаа.

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг "www.shilendans.gov.mn", "immigration.gov.mn" цахим хуудсанд тайлант хугацаанд нийт 770 мэдээлэл оруулахаас 750 мэдээлэл оруулж, 20 мэдээлэл хоцорч 97.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутаг дахь газрын дарга буюу төсвийн шууд захирагчийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийж "Зөрчилгүй санал дүгнэлт" авсан. 2019 оны эхний хагас жилийн байдлаар төв болон орон нутаг дахь газрууд харилцагч байгууллагуудтай ямар нэгэн өгөх өр төлбөр, авах авлагагүй ажилласан байна.

Худалдан авах ажиллагааны 2019 оны төлөвлөгөөний дагуу нийт дөрвөн тендерийн урилгыг байгууллагын цахим хуудастаа байршуулан нээлттэй шалгаруулалтын аргаар хоёр, харьцуулалтын аргаар хоёр тендерийг тус тус зохион байгуулсан бөгөөд бүх бараа үйлчилгээ, худалдан авалтыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 101-д заасны дагуу дотоодын үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдээс нийлүүлээ. Батлагдсан төсвийн хүрээнд 176,9 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж, 209,9 сая төгрөгийн албаны дүрэмт хувцасны нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гэрээ байгуулан, гэрээнд заасан хуваарийн дагуу хангалтыг хийж, гэрээг дүгнэн ажиллалаа.



Авто машины парк шинэчлэх ажлын хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гадаадын иргэний хяналт шалгалт явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Өмнөд бүс дэх газар, Хойд бүс дэх газар, Баян-Өлгий аймаг дахь хэлтэс, Говь-Алтай аймгийн төлөөллийг туулах чадвар сайтай авто машинаар хангалаа.

2019 онд хийх бүтээн байгуулалтын хүрээнд байгууллагын төв байрны гадна шилэн фасад засварын ажлыг 14,8 сая, байгууллагын хурлын танхимыг өргөтгөн шинэчлэх засварын ажлыг 19,8 сая, зочид хүлээн авах уулзалтын өрөөг шинэчлэх засварын ажлыг 6,6 сая, уулзалтын өрөөг 4,5 сая, төв байрны гадна хоёр хаалга, хаалт хийх ажлыг 10,5 сая, архивын өрөөг засаж тохижуулахад 2,6 сая төгрөгийн төсвөөр, Дорноговь аймаг дахь газрын албаны байрын дээвэр засварын ажлыг орон нутгийн хөрөнгө оруулалтын 28,7 сая төгрөгийн санхүүжилтээр тус тус хийж гүйцэтгэлээ. Байгууллагын түүхийг харуулсан үзмэр бүхий музейн өрөө байгуулахад гарах зардлын тооцоог гарган төсвийг баталж, албан хаагчдын дотоод нөөц бололцоог дайчлан засварын ажлыг эхлүүлсэн.

Байгууллагын даргын 2019 оны А/170 дугаар "Албан хаагчдын хүүхдийн цэцэрлэг байгуулах ажлын хэсэг томилох тухай" тушаалыг баталж, уг тушаалын дагуу "Байгууллагын дэргэдэх хүүхдийн цэцэрлэг байгуулах ажлын төлөвлөгөө"-г 05 дугаар сард батлан засварын ажлыг эхлүүлж, 09 дүгээр сарын 02-ний өдөр цэцэрлэгийн нээлтийг хийж, хүүхэд багачуудаа хүлээн авсан. Тус цэцэрлэг нь байгууллагын төвийн Б байрны нэгдүгээр давхарт гурван бүлгээр хичээллэж байна. Цэцэрлэгийн засвар үйлчилгээнд тус байгууллагаас нийт 56.0 сая төгрөгийн төсөв зарцуулсан.



2.3 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, ГАДААД ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Тайлангийн хугацаанд хуулийн зургаан төсөл, Засгийн газрын тогтоолын дөрвөн төсөл, Олон улсын, хамтын ажиллагааны хэлэлцээрийн гурван төсөл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалын таван төслийг тус тус санал өгсөн байна. Мөн байгууллагын даргын баталсан дотоод үйл ажиллагааг зохицуулсан найман журмыг шинээр, таван журмыг шинэчлэн батлуулж, зургаан журамд нэмэлт, өөрчлөлт оруулан дээрх өөрчлөлттэй холбогдуулан есөн журмыг хүчингүй болгож, бусад байгууллагатай хамтран ажиллах нэг журмыг батлуулан ажиллалаа.

Тус байгууллагаас төрийн бусад байгууллагатай хамтран ажиллах талаар 2001 оноос хойш байгуулсан 16 гэрээ, журам, тушаал болон санамж бичгүүдийг цэгцлэх ажлын хүрээнд дээрх эрх зүйн актуудын хэрэгжилтийг дүгнэх, цаашид хэрхэх тухай санал солилцох талаар албан бичиг боловсруулан Татварын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Авто тээврийн үндэсний төвд тус тус хүргүүлсэн.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дэд ажлын хэсгийн хэсгээс хуулийн төсөлд тусгах нэмэлт, өөрчлөлтийн саналыг нэгтгэн боловсруулж 04 дүгээр сард байгууллагын удирдлагад танилцуулан, удирдлагаас өгсөн холбогдох саналыг хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтөд тусгаснаар 05 дугаар сард дахин танилцуулсан. Хуулийн төслийг 07 дугаар сарын 02-ны өдөр Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлснээр хуулийн төслийг эцсийн байдлаар хянан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газарт 07 дугаар сарын 08-ны өдөр хүргүүлж ажиллав. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хуралдаанд 2019 оны 09 дүгээр сарын 17, 10 дугаар сарын 01, 11 дүгээр сарын 14, 12 дугаар сарын 03-нд тус тус байгууллагын холбогдох албан тушаалтнууд оролцож, Хууль зүй, дотоод хэргийн яаманд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, түүнийг дагаж батлагдах хуулийн төслүүдийн талаар 2019 оны 01/1666, 01/1917, 1/2105 дугаар албан бичгүүдээр санал өгсөн.

Гадаадын иргэн, харьяатын газарт холбогдох иргэний нэг, захиргааны долоо нийт найман хэрэгт Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн хуулийн ахлах мэргэжилтэн, хуулийн мэргэжилтэн нар байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож ажиллав.



Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэх нээлттэй хэлэлцүүлэг 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн “Хуульчдын танхим”-д зохион байгуулагдсан.

Хэлэлцүүлэгт Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, бусад төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлүүд оролцсон бөгөөд тус байгууллагаас Дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг оролцлоо. Мөн тус хэлэлцүүлэх арга хэмжээнд дэд дарга Д.Түвшинтөр “Гадаадын иргэний эрх зүйн байдлын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал” сэдвээр танилцуулга хийв.

Шинээр томилогдохоор нэр дэвшсэн 29, шилжин томилогдохоор нэр дэвшсэн 28, дэвшин томилогдохоор нэр дэвшсэн 15, сэлгэн ажиллахаар нэр дэвшсэн хоёр, нийт 74 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлэв.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөртэй холбогдуулан 16 зорилтын хүрээнд 62 арга хэмжээ бүхий “Гадаадын иргэн, харьяатын газраас авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2019 онд авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”, 10 зорилтын хүрээнд 11 арга хэмжээ бүхий “Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г тус тус батлан хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллалаа.



Тайлангийн хугацаанд байгууллагын удирдлагууд оролцсон найман удаагийн гадаад томилот болон бусад айлчлал, хурал, арга хэмжээнд байгууллагын нийт 28 албан хаагчийг Бүгд Найрамдах Австри Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Итали Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, ХБНГУ, Тайвань, Тайландын Вант Улсуудад гадаад томилолтоор хамруулах ажлыг тухай бүр зохион байгуулж ажиллав.



Гадаад хамтын ажиллагаатай байгууллагын төлөөлөгчидтэй хийх 35 удаагийн албан уулзалтыг зохион байгуулсан ба Бүгд Найрамдах Солонгос Улсын Хууль зүйн яамны Цагаачлал, шилжилт хөдөлгөөний албаны дарга ноён Ча Гюү-гын тэргүүтэй төлөөлөгчид, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимийн орлогч дарга Лиан Линниань тэргүүтэй төлөөлөгчид, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимийн Хилээр орох гарахыг хариуцах газрын орлогч дарга Баян-Эрдэнэ тэргүүтэй төлөөлөгчдийг тус тус хүлээн авах ажлыг зохион байгуулан ажиллав.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Катар Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Тажикстан Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Тайвань зэрэг улсад богино, дунд, урт хугацааны есөн сургалтад 31 албан хаагчийг уригч талын зардлаар гадаад сургалтад хамруулсан.

2.4 МЭДЭЭЛМИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР

Үндэсний дата төв УТУГ-тай байгуулсан 2018 оны 05 сарын 29-ний өдрийн 0193 дугаар гэрээний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 259 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын дагуу 9 төрлийн мэдээллийг Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем 2019 оны 11 сарын 11-ний өдөр гаргасан бөгөөд Үндэсний мэдээллийн портал "MGOV.mn" системээр дамжуулан Төрийн бусад байгууллагууд авч ашиглах бүрэн боломжтой болов.

Зорчигчийн урьдчилсан мэдээллийн дэвшилтэд систем "APP"-ийг Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгсэл, гадаадын иргэний бүртгэл, хяналтын нэгдсэн систем "ISM"-тэй холбох бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд шаардлагатай байгаа тоног төхөөрөмж, програм хангамжийн судалгааг гарган албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн албан бичгийн дагуу "Женералтеч" ХХК-тай 248.5 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, программ хангамжийг худалдан авах тухай гэрээ байгуулж, гурван ширхэг сервер холбогдох эрх, лицензүүдийг хүлээн аваад байна. Мөн байгууллагын дотоод сүлжээнд байсан "DELL R320" болон "DELL R710" серверүүдийг өндөр хурдны "DELL R740XD" серверт нэгтгэж шилжүүлснээр тус системийн аюулгүй байдал сайжирч, нэвтрэх хурд гурав дахин нэмэгдсэн.





2.5 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР

Хяналт-шинжилгээ, үнэлгээг нийт 38 удаа хийн тайланг гаргаж, тухай бүр холбогдох байгууллага болон удирдлагад илтгэх хуудсаар танилцуулж ажилласнаас бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд найм, байгууллагын үйл ажиллагаанд хоёр, байгууллагын нээлтэй байдалд нэг, байгууллагын дотоодод чиглэсэн үйл ажиллагаанд 27 удаагийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийжээ.



Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/65 дугаар тушаал болон байгууллагын даргын 2019 оны А/165 дугаар тушаалаар байгууллагын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийх, дахин хуваарилах, холбогдох санал, дүгнэлтийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан холбогдох хууль тогтоомжийг судлан, ерөнхий нэг, үндсэн дөрөв, дэд таван чиг үүргийг боловсруулсан.



2019 онд төсөв, санхүүгийн чиглэлээр хоёр, хууль тогтоомжийн хүрээнд дөрөв, үйл ажиллагааны чиглэлээр хоёр, нийт төлөвлөгөөт найм, төлөвлөгөөт бус дөрвөн удаагийн аудитын хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, шалгалтын тайланг удирдамжид заасан хугацаанд илтгэх хуудсаар танилцуулж, холбогдох чиглэл авч ажилласан.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Монгол Улсын Ерөнхий сайдын Ажлын алба, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндэсний статистикийн хороонд холбогдох статистик тоон мэдээллийг 73 удаа хүргүүлээ

2.6 ХИЛИЙН БООМТ, ОРОН НУТГИЙН ЧИГЛЭЛЭЭР

Байгууллагын даргын 2019 оны А/06 дугаар тушаалаар байгуулагдсан “Зорчигчийн урьдчилсан мэдээллийн системийг нэвтрүүлэх ажлын хэсэг”-ээс Иргэний нисэхийн ерөнхий газарт хүсэлт тавьж, тус байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу гадаадын дөрвөн байгууллагатай холбоо тогтоон, олон улсын иргэний агаарын тээврийн мэдээллийн технологийн чиглэлээр APP-ийн үйлчилгээ үзүүлдэг хоёр байгууллага болох “СИТА”, “РОКВЕЛЛ КОЛЛИНС” /АРИНК/ компаниас гэрээний төслийг хүлээн авч, “СИТА” компанийн төлөөлөлтэй 02 дугаар сард уулзалт хийж, гэрээний төслийг зүйл тус бүрээр ярилцан, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан бичгээр ирүүлсэн гэрээний төсөлд тусгах нэмэлт саналуудыг нэгтгэн 04 дүгээр сард “СИТА” компанид хүргүүлсэн бөгөөд “РОКВЕЛЛ КОЛЛИНС” /АРИНК/ компанийн төлөөлөгчтэй 01 дүгээр сард уулзалт зохион байгуулж, Засгийн газрын 2019 оны 306 дугаар тогтоолыг танилцуулан APP/iAPI системийн хоорондын ялгаа, төлбөр хураах аргачлалын талаар санал солилцсон.

“СИТА” компанитай гэрээний төслийг эцэслэх, үнийн дүнг тохиролцох, мөн төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэлэлцэх зорилгоор 06 дугаар сард “РОКВЕЛЛ КОЛЛИНС” /АРИНК/ компаниас ирүүлсэн гэрээний төслийг судлан, уулзалт хэлэлцээрийг мөн 06 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулаа.



Нэгдсэн Үндэстний Байгууллагын өөрийн гишүүн улсуудад Зорчигчийн урьдчилсан мэдээлийн системийг нийлүүлж эхэлсэнтэй холбогдуулан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Терроризмтой тэмцэх албаны Бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга Мухаммад Рафуйддин Шахтай байгууллагын дарга Д.Мөрөн Улаанбаатар хотноо 06 дугаар сарын 21-ний өдөр Гадаад харилцааны яаманд уулзаж, тус байгууллагаас хэрэгжүүлж буй “goTravel” хөтөлбөр, Монгол Улсад хэрэгжих гэж буй Зорчигчийн урьдчилсан мэдээлийн дэвшилтэд систем (APP/iAPI)-ийн талаар санал солилцсон. Уулзалтын дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын “goTravel” хөтөлбөрт Монгол Улс хамрагдах хүсэлтийг Терроризмтой тэмцэх албаны хэлтсийн дарга Мухаммад Рафуйдин Шахад 2019 оны 01/1214 дүгээр албан бичгээр гаргаж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Терроризмтой тэмцэх албаны Террорист этгээдийн шилжилт, хөдөлгөөнтэй тэмцэх хөтөлбөрийн дарга Йеме Постматай 10 дугаар сарын 07-ны өдөр Гадаад харилцааны яам дээр тус байгууллагын удирдлага уулзлаа. Мөн Засгийн газрын 2018 оны 306 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх танилцуулгыг Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит хурал, Агаарын тээврийн хялбаршуулах Зөвлөлийн дэргэдэх нарийн бичгийн даргын ажлын албаны 11 дүгээр сарын 08-ын өдрийн хурал, Агаарын тээврийг хялбаршуулах Зөвлөлийн 6 дугаар хурлаар тус тус танилцуулав.

Дорнод аймаг дахь Зүүн бүс дэх газраас 02 дугаар сард, Ховд аймаг дахь Баруун бүс дэх газраас 04 дүгээр сард, Сэлэнгэ аймаг дахь Хойд бүс дэх газраас 05, 10 дугаар сард орон нутаг дахь төрийн байгууллагуудтай хамтран, Агаарын замын боомт хариуцсан газраас 05 дугаар сард “Чингис хаан” олон улсын нисэх буудалд үйл ажиллагаагаа явуулдаг хууль хяналтын байгууллагуудтай хамтран, Дорноговь аймаг дахь газраас 11 дүгээр сард нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааны талаар олон нийтэд сурталчлан танилцуулав.

Монгол Улсын хилээр нэвтэрч буй гадаадын иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих ажлын хүрээнд:

- Тус байгууллагаас гадаадын иргэдийн хил нэвтрэлтэд хяналт тавьж 1132 зөрчил илрүүлсэн ба зөрчилтэй холбогдуулан “ISM” программд түр ирэгчийн тухайн жилд байх 180 хоногийг тоолж уг хугацаанаас илүү гарсан гадаадын иргэдийг манай байгууллагад шилжүүлэн ажиллахыг Хил хамгаалах ерөнхий газарт мэдэгдэн программд нэмэлт өөрчлөлтийг хийлгүүлсэн;

- Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар, Монгол Улсын өргөмжит консулын газраас алдаатай олгосон болон засвартай нийт 63 орны 708 гадаадын иргэний визийн зөрчил, Монгол Улсаас албадан гаргасан иргэдэд орохыг үл зөвшөөрсөн хугацаанд виз олгохгүй байх үүргийг зөрчиж олгосон гадаадын дөрвөн иргэний визийн зөрчлийг нэгтгэн, мөн виз хүсэгчтэй ярилцлага хийлгүйгээр гадаадын иргэний зорчиж буй зорилгод нийцээгүй ангиллын виз олгосны улмаас Монгол Улсын хилийн боомтод тухайн иргэдтэй ярилцлага хийн 1271 гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлээгүй буцаасан мэдээлийг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргад албан бичгээр хүргүүлсэн;

- “Гадаадын иргэний бүртгэл, хяналтын нэгдсэн систем” буюу /ISM/-программ ажиллахгүй, сүлжээ саатсан үед “Онцгой үед виз хэвлэх программ”-ын хэрэглэгчийн шаардлагыг боловсруулсан;

- Гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаах тохиолдолд баримтлах зааврыг гарган байгууллагын даргын 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар батлуулаа.

“Торгоны зам-2019” авто рали уралдаанд оролцогч тамирчид болон арын албаны бүрэлдэхүүн нийт 1752 гадаадын иргэн Алтанбулаг авто замын боомт, Өмнөговь аймгийн Ханбумбат нисэх буудал, Гашуунсүхайд авто замын боомтоор тус тус улсын хил нэвтэрсэн бөгөөд гадаадын иргэний виз, бүртгэлтэй холбоотой ямар нэгэн зөрчил, хүндрэл үүсгэлгүй ажиллалаа.





ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Засгийн газраас 2019 оныг “ Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан:

- Байгууллагын үйлчилгээний танхим дахь үйлчлүүлэгчийн дугаар дуудагч төхөөрөмж зөвхөн монгол хэлний сонголттой байсныг хөгжүүлэн англи, орос, хятад хэлний сонголтыг нэмсэн;

- Гадаадын иргэдийн бүртгэлийн журамтай холбоотой санамж мэдээлмээр 60 секундийн видео санамж, товч ярилцлага, зурагт хуудсыг англи, монгол хэлээр бэлтгэн олон нийтэд хүргэсэн;

- Мэдээллийн дэлгэц /kiosk/-ийг үйлчилгээний танхимд байршуулан монгол, англи, солонгос, хятад хэл дээр долоон хэсэг мэдээллийг дөрвөн төрөлд хуваан үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн;

- Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвд тус байгууллагын үйлчилгээг үзүүлж эхэлсэн;

- Хилийн боомтод виз, визийн зөвшөөрөл олгох үйлчилгээг цахимаар олгож эхэлсэн нь иргэд, үйлчлүүлэгчдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай үзүүлэх, виз олгох нөхцөлийг хөнгөвчлөх зэрэг таатай нөхцлийг бүрдүүлж өгсөн;

- Иргэд, үйлчлүүлэгчдэд гадаадын иргэдийн бүртгэлийн талаарх мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор лавлагаа, мэдээллийн 1800-1882 дугаар утсан дээр автомат хариулагчийн системийг шинээр хийсэн;

- Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2002 оны 213 дугаар тушаалаар “Визийн хуудас”-ны төлбөр 3 ам.доллар түүнтэй тэнцэх хэмжээний мөнгөн тэмдэгийг улсын тэмдэгийн хураамж дээр нэмж авдаг байсан нь хууль тогтоомжид нийцэхгүй тул энэ оны 06 дугаар сараас эхлэн зогсоосон.

Хууль эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг эцсийн байдлаар боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлснээр тус яамнаас олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж Засгийн газрын хуралдаанаар оруулахад бэлэн болсон.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд байгууллагын дэргэдэх хүүхдийн цэцэрлэгийн бүтээн байгуулалтыг хийж хичээлийн шинэ жилээр нээлтээ хийснээр албан хаагчдын ажлын цаг ашиглалт сайжирч, ажлын бүтээмж өссөн зэрэг болно.

Дээр дурдсан ололт амжилтыг бататган 2020 онд дараах зорилтыг дэвшүүлж байна:

- Хууль эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төсөл батлагдсан тохиолдолд холбогдох дүрэм, журамд шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлт хийж;

- Гадаадын иргэдэд тавих бүртгэл, хяналтын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх зорилтын хүрээнд Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудалд зорчигчийн урьдчилсан мэдээллийн “APP” дэвшилтэт системийг нэвтрүүлэх ажлын дүнг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, холбогдох гэрээг байгуулах бэлтгэл ажлыг хангах;

- Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймагт барих албаны байрыг барьж, ашиглалтад оруулах,

- Төрийн албаны сахилга хариуцлага, ажлын цаг ашиглалт, бүтээмжид тавих хяналтыг сайжруулах;

- Гадаадын иргэдэд үзүүлэх цахим үйлчилгээг илүү боловсронгуй болгох;

- Төсвийн сахилга батыг чанд сахиж, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, өр авлага үүсгэлгүй ажиллах зэрэг болно.



